**МОНГОЛ УЛС**
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2011 оны 10 сарын 12 өдөр    Дугаар 294    Улаанбаатар хот

“Санар” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг
түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалт болон Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Санар” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацааг 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн хугацаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг “Санар” ХХК/Б.Энхбаяр/-д анхааруулсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА    Д.БАЯРСАЙХАН